



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар Д/125

Хэрлэн сум

Э.Алтанцацралын сургалтын төлбөрт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, „Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” арвантавдугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Зөгийн үүр” арга хэмжээний хүрээнд “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Бэрх тосгоны иргэн Э.Алтанцацралын сургалтын төлбөрт зориулж 3,400,000 (гурван сая дөрвөн зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Зөгийн үүр” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ